

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/02/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: А.Нанжидмаа

Утас: 70453721, Цахим хаяг: Nanjidmaaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	15
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
4. Аудитын тайлан.....	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. Аудитын илрүүлэлт	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.03.24 № УВА-2023/02/НА-СГА-073
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд нэгтгэсэн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Засаг даргын тамгын газрын нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 3.2 сая төгрөгийг ажилчдын аялал зугаалгад зориулж төсвийг үр ашиггүй зарцуулсан, Засаг даргын тамгын газрын жолоочтойгоо Хантер маркын авто машинд засвар хийлгэх зорилгоор гэрээ байгуулж, жолоочийн данс руу 18.0 сая төгрөгийг шилжүүлж, Хантер маркын машины эвдрэл гэмтлийг тогтоосон авто засварын газрын оношилгооны дүгнэлт байхгүй, засвар үйлчилгээ хийсэн эсэх нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байгаа, Өндөрхангай сумын Соёлын төвийн даргад 0.2 сая төгрөгийн ээлжийн амралтын цалин илүү тооцон олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад “Өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйл “Бусад хангамж” 12.1.4 дэх заалтад

“Хуулиар зөвшөөрөөгүй бусад” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6-д “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх”, УСНББОУС-1 “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө 98.2 хувийн биелэлттэй байхад аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/697 дугаар захирамжийн дагуу сумын орон нутгийн орлогоос 15.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн орлогод татаж авсан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,042,613,862.27	647,021,678.59
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	545,226,607.33	390,914,102.14
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	545,226,607.33	390,914,102.14
31210	Төгрөг	545,226,607.33	390,914,102.14
31211	Төрийн сангийн харилцах	545,226,607.33	390,914,102.14
33	АВЛАГА	272,043,754.00	195,386,106.25
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	119,987,700.00	0.00
33500	Бусад авлага	67,491,588.00	15,661,280.25
33510	Байгууллагаас авах авлага	27,000,000.00	55,845.25
33520	Хувь хүмүүсээс авах авлага	40,491,588.00	15,605,435.00
33600	Зээлийн авлага	84,564,466.00	179,724,826.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	84,564,466.00	179,724,826.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	84,564,466.00	179,724,826.00
35	БАРАА МАТЕРИАЛ	225,343,500.94	60,721,470.20
35100	Түүхий эд материал	46,916,319.43	0.00
35110	Тусгай зориулалттай материал	23,166,478.53	0.00
35130	Эм боох материал	23,749,840.90	0.00
35400	Хангамжийн материал	178,427,181.51	56,724,137.20
35410	Бичиг хэргийн материал	22,551,520.20	2,098,550.00
35420	Аж ахуйн материал	101,808,881.15	8,815,205.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,798,000.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	776,800.00	0.00
35450	Барилгын засварын материал	3,497,000.00	130,000.00
35460	Хүнсний материал	21,291,082.50	0.00
35470	Бусад хангамжийн материал	26,703,897.66	45,680,382.20
35600	Мал амьтад	0.00	3,997,333.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,787,952,870.44	1,594,676,634.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,787,952,870.44	1,594,676,634.95
39200	Биет хөрөнгө	5,602,994,270.35	1,475,106,634.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,441,056,887.19	1,380,253,619.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	-884,215,195.87	-527,466,825.61
39203	Авто-тээврийн хэрэгсэл	411,094,905.00	327,494,905.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-142,904,262.97	-115,482,552.24
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,114,170,584.39	625,644,410.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-674,610,021.78	-376,502,027.31
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	294,668,519.14	61,184,489.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	-175,205,567.62	-43,125,946.30
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	40,700,178.00	0.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	261,805,298.60	277,083,852.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-116,144,517.62	-133,977,291.24
39217	Ном	32,577,463.89	0.00
39300	Биет бус хөрөнгө	184,958,600.09	119,570,000.04
39301	Програм хангамж	7,215,000.00	3,825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,179,999.91	-3,324,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	183,923,600.00	119,070,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,830,566,732.71	2,241,698,313.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	33,942,016.60	5,332,573.48
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	33,942,016.60	5,332,573.48
41300	Өглөг	33,942,016.60	5,332,573.48

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	202,769.00
41360	Бусад өглөг	33,942,016.60	5,129,804.48
41361	Байгууллагад төлөх өглөг	33,942,016.60	5,129,804.48
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,796,624,716.11	2,236,365,740.06
51	Засгийн газрын хувь оролцоо	6,796,624,716.11	2,236,365,740.06
51100	Засгийн газрын оруулсан капитал	3,622,651,021.68	773,745,420.50
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	3,622,651,021.68	773,745,420.50
51200	Хуримтлагдсан үр дүн	1,844,310,921.80	1,150,871,061.45
51210	Өмнөх үеийн үр дүн	615,959,958.27	5,491,701,745.10
51220	Тайлант үеийн үр дүн	1,228,350,963.53	-4,340,830,683.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,329,662,772.63	311,749,258.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,830,566,732.71	2,241,698,313.54

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,737,265,388.53	3,007,867,537.96
11	ТАТВАРЫН ОРЛОГО	217,415,601.31	386,526,782.36
110	Орлогын албан татвар	67,116,308.31	197,504,739.04
1100	Хувь хүний орлогын албан татвар	67,116,308.31	197,504,739.04
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	0.00	154,526,293.39
110002	Үйл ажиллагааны орлого	11,813,348.33	9,505,840.22
110003	Хөрөнгийн орлого	47,263,679.98	32,010,573.43
110004	Хөрөнгө борлуулсны орлого	5,319,600.00	689,200.00
110008	Шууд бус орлого	2,719,680.00	772,832.00
113	Хөрөнгийн албан татвар	90,478,830.00	141,968,613.32
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0.00	2,193,083.32
113002	Бууны албан татвар	2,460,000.00	2,524,000.00
113004	Малд ногдуулах албан татвар	88,018,830.00	137,251,530.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	59,820,463.00	47,053,430.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,439,240.00	5,647,200.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,296,240.00	1,536,600.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	143,000.00	4,110,600.00
1181	Газрын төлбөр	969,445.00	3,808,555.00
118101	Газрын төлбөр	969,445.00	3,808,555.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	57,411,778.00	37,597,675.00
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	56,901,778.00	35,875,388.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.00	640,000.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	510,000.00	1,082,287.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,358,158,762.65	460,429,513.92
120	Нийтлэг татварын бус орлого	1,358,158,762.65	460,429,513.92
120003	Торгуулийн орлого	18,325,500.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	184,618,971.54	106,455,503.69
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,492,047.00	14,627,531.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	133,126,924.54	91,827,972.69
120009	Бусад орлого	1,260,000.00	13,928,495.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,141,261,618.00	340,045,515.23
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	12,692,673.11	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,161,691,024.57	2,160,911,241.68
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,032,565,779.00	261,023,800.00

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,851,683,900.00	0.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	180,881,879.00	261,023,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	231,458,154.00	9,870,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	16,591,000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,896,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,065,000.00	9,870,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	146,906,154.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,665,312,700.00	1,837,088,260.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	896,514,100.00	1,216,850,260.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	768,798,600.00	620,238,000.00
1330	Төсвийн захирагчдаас	55,422,761.57	52,929,181.68
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,422,761.57	52,929,181.68
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	176,931,630.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	176,931,630.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,283,938,030.62	2,436,628,606.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,283,938,030.62	2,436,628,606.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,176,931,598.83	1,140,451,664.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,891,941,250.10	395,414,618.45
210101	Үндсэн цалин	1,464,810,479.64	299,384,176.78
210102	Нэмэгдэл	233,902,244.40	46,575,234.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,944,045.00	0.00
210104	Урамшуулал	119,490,983.97	21,673,805.00
210105	Гэрээт ажлын хөлс	64,793,497.09	27,781,402.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,597,985.54	48,851,008.93
210201	Тэтгэврийн даатгал	171,838,723.48	33,251,996.89
210202	Тэтгэмжийн даатгал	17,823,602.89	3,973,549.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,379,856.38	3,194,028.24
210204	Ажилгүйдлийн даатгал	3,524,309.15	765,975.58
210205	Эрүүл мэндийн даатгал	34,031,493.64	7,665,458.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	264,381,508.67	300,946,015.27
210301	Гэрэл, цахилгаан	10,461,868.61	29,681,900.19
210302	Түлш, халаалт	253,076,840.06	270,964,115.08
210303	Цэвэр, бохир ус	842,800.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	95,601,855.90	90,980,489.90
210401	Бичиг хэрэг	12,283,526.00	12,233,348.00
210402	Тээвэр, шатахуун	58,558,190.00	48,186,345.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,992,299.90	2,440,631.90
210404	Ном, хэвлэл	276,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,539,040.00	1,640,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,568,300.00	16,517,285.00
210408	Бараа материал акталсны зардал	3,384,500.00	9,962,880.00
2105	Норматив зардал	167,389,411.50	1,500,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	116,969,353.50	0.00
210502	Хоол, хүнс	47,599,558.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,820,500.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,125,900.00	63,541,700.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	539,300.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	83,000.00	0.00
210604	Урсгал засвар	6,503,600.00	63,541,700.00
2107	Томилолт, зочны зардал	8,376,000.00	6,772,000.00
210702	Дотоод албан томилолт	8,376,000.00	6,772,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,281,047.55	5,167,982.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,602,811.55	2,156,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,879,200.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	461,550.00	118,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220,274.00	192,242.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	121,000.00	195,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,078,500.00	1,103,900.00
210807	Газрын төлбөр	917,712.00	862,140.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	462,236,639.57	227,277,850.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,907,560.00	21,253,410.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,635,400.00	11,741,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	367,693,679.57	194,282,640.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,107,006,431.79	1,296,176,941.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	120,030,417.60	26,397,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,855,992.60	16,737,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	57,174,425.00	9,660,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,483,000.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,483,000.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	951,936,861.57	1,269,779,441.68
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	896,514,100.00	1,216,850,260.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,422,761.57	52,929,181.68
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,556,152.62	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,556,152.62	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,453,327,357.91	571,238,931.69
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	224,976,394.38	4,912,069,615.34
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	2,018,017.08	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	8,198,397.30	0.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	214,759,980.00	4,732,624,842.85
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0.00	179,444,772.49
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,228,350,963.53	4,340,830,683.65

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,410,075,734.88	2,592,833,690.04
11	ТАТВАРЫН ОРЛОГО	217,415,601.31	386,526,782.36
110	Орлогын албан татвар	67,116,308.31	197,504,739.04
1100	Хувь хүний орлогын албан татвар	67,116,308.31	197,504,739.04
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	0.00	154,526,293.39
110002	Үйл ажиллагааны орлого	11,813,348.33	9,505,840.22
110003	Хөрөнгийн орлого	47,263,679.98	32,010,573.43
110004	Хөрөнгө борлуулсны орлого	5,319,600.00	689,200.00
110008	Шууд бус орлого	2,719,680.00	772,832.00
113	Хөрөнгийн албан татвар	90,478,830.00	141,968,613.32
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0.00	2,193,083.32
113002	Бууны албан татвар	2,460,000.00	2,524,000.00
113004	Малд ногдуулах албан татвар	88,018,830.00	137,251,530.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	59,820,463.00	47,053,430.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,439,240.00	5,647,200.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,296,240.00	1,536,600.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	143,000.00	4,110,600.00
1181	Газрын төлбөр	969,445.00	3,808,555.00
118101	Газрын төлбөр	969,445.00	3,808,555.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	57,411,778.00	37,597,675.00
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	56,901,778.00	35,875,388.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.00	640,000.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	510,000.00	1,082,287.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	145,473,809.00	45,395,666.00
120	Нийтлэг татварын бус орлого	145,473,809.00	45,395,666.00
120003	Торгуулийн орлого	18,325,500.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	125,888,309.00	31,467,171.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	125,888,309.00	31,467,171.00
120009	Бусад орлого	1,260,000.00	13,928,495.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,047,186,324.57	2,160,911,241.68
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,032,565,779.00	261,023,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,851,683,900.00	0.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	180,881,879.00	261,023,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	236,941,154.00	9,870,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	16,591,000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,896,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,065,000.00	9,870,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	152,389,154.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,665,312,700.00	1,837,088,260.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	896,514,100.00	1,216,850,260.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	768,798,600.00	620,238,000.00
1330	Төсвийн захирагчдаас	55,422,761.57	52,929,181.68
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,422,761.57	52,929,181.68

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	56,943,930.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	56,943,930.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,913,889,058.77	2,214,878,126.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,913,889,058.77	2,214,878,126.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,827,676,899.58	916,353,718.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,889,296,920.65	395,435,565.95
210101	Үндсэн цалин	1,459,263,258.81	294,233,016.06
210102	Нэмэгдэл	235,163,648.40	49,987,064.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,944,045.00	0.00
210104	Урамшуулал	122,149,194.97	21,673,805.00
210105	Гэрээт ажлын хөлс	63,776,773.47	29,541,680.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	247,691,996.76	49,127,168.20
210201	Тэтгэврийн даатгал	175,317,317.72	33,563,294.46
210202	Тэтгэмжийн даатгал	18,205,394.26	3,964,815.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,601,255.91	3,186,760.66
210204	Ажилгүйдлийн даатгал	3,613,662.27	764,408.77
210205	Эрүүл мэндийн даатгал	35,954,366.60	7,647,888.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	280,531,702.27	300,946,015.27
210301	Гэрэл, цахилгаан	10,461,448.61	25,293,309.39
210302	Түлш, халаалт	269,227,453.66	275,352,705.88
210303	Цэвэр, бохир ус	842,800.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	100,602,181.90	34,304,346.90
210401	Бичиг хэрэг	7,398,632.00	1,890,890.00
210402	Тээвэр, шатахуун	57,763,750.00	25,778,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,967,299.90	2,440,631.90
210404	Ном, хэвлэл	683,600.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,836,000.00	1,756,955.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,952,900.00	2,437,450.00
2105	Норматив зардал	146,121,390.00	2,140,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	85,825,231.00	0.00
210502	Хоол, хүнс	55,049,659.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,246,500.00	2,140,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,715,900.00	65,511,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,199,300.00	620,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	583,000.00	0.00
210604	Урсгал засвар	8,933,600.00	64,891,700.00
2107	Томилолт, зочны зардал	8,376,000.00	6,772,000.00
210702	Дотоод албан томилолт	8,376,000.00	6,772,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,055,548.00	7,351,982.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,377,312.00	4,340,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,879,200.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	461,550.00	118,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220,274.00	192,242.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	121,000.00	195,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,078,500.00	1,103,900.00
210807	Газрын төлбөр	917,712.00	862,140.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,285,260.00	54,764,940.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,821,510.00	42,138,940.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,463,750.00	12,626,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,086,212,159.19	1,298,524,407.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	99,236,145.00	27,558,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,061,720.00	16,737,300.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	57,174,425.00	10,821,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,483,000.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,483,000.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	951,936,861.57	1,269,779,441.68
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	896,514,100.00	1,216,850,260.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,422,761.57	52,929,181.68
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,556,152.62	1,186,266.23
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,556,152.62	0.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	0.00	1,186,266.23
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	496,186,676.11	377,955,563.81
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	259,402,980.00	420,268,069.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	259,402,980.00	420,268,069.00
2200	Дотоод эх үүсвэрээр	259,402,980.00	420,268,069.00
223001	Бусад хөрөнгө	243,759,980.00	411,864,069.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,643,000.00	8,404,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-259,402,980.00	-420,268,069.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	-112,000,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	112,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	0.00	112,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	236,783,696.11	-154,312,505.19
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	308,442,911.22	545,226,607.33
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	545,226,607.33	390,914,102.14

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,979,446,547.68	1,127,989,109.16	937,224,998.12	5,044,660,654.96
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,478,557.80	1,478,557.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,979,446,547.68	1,127,989,109.16	938,703,555.92	5,046,139,212.76
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-1,478,557.80	0.00	-1,478,557.80
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	643,204,474.00	203,152,221.27	-322,743,597.65	523,613,097.62

8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,228,350,963.53	1,228,350,963.53
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,622,651,021.68	1,329,662,772.63	1,844,310,921.80	6,796,624,716.11
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,622,651,021.68	1,329,662,772.63	1,844,310,921.80	6,796,624,716.11
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-269,822,340.62	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	773,745,420.50	311,749,258.11	1,574,488,581.18	2,659,983,259.79
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-	-
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	773,745,420.50	311,749,258.11	1,150,871,061.45	2,236,365,740.06

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,856,038,300.00	1,466,310,487.32	389,727,812.68	79.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	987,838,300.00	942,446,418.32	45,391,881.68	95.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	959,701,400.00	914,887,718.32	44,813,681.68	95.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	405,916,100.00	395,435,565.95	10,480,534.05	97.42
210101	Үндсэн цалин	361,443,100.00	294,233,016.06	67,210,083.94	81.41
210102	Нэмэгдэл	0.00	49,987,064.11	-49,987,064.11	0.00
210104	Урамшуулал	12,553,000.00	21,673,805.00	-9,120,805.00	172.66
210105	Гэрээт ажлын хөлс	31,920,000.00	29,541,680.78	2,378,319.22	92.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,904,000.00	49,127,168.20	1,776,831.80	96.51
210201	Тэтгэврийн даатгал	34,638,800.00	33,563,294.46	1,075,505.54	96.90
210202	Тэтгэмжийн даатгал	4,075,200.00	3,964,815.56	110,384.44	97.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,260,400.00	3,186,760.66	73,639.34	97.74
210204	Ажилгүйдлийн даатгал	814,800.00	764,408.77	50,391.23	93.82
210205	Эрүүл мэндийн даатгал	8,114,800.00	7,647,888.75	466,911.25	94.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	305,309,000.00	300,946,015.27	4,362,984.73	98.57
210301	Гэрэл, цахилгаан	26,913,300.00	25,293,309.39	1,619,990.61	93.98
210302	Түлш, халаалт	276,895,700.00	275,352,705.88	1,542,994.12	99.44
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	300,000.00	1,200,000.00	20.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,698,000.00	31,124,346.90	4,573,653.10	87.19
210401	Бичиг хэрэг	2,310,100.00	1,890,890.00	419,210.00	81.85
210402	Тээвэр, шатахуун	24,179,500.00	24,022,420.00	157,080.00	99.35

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,684,200.00	2,440,631.90	243,568.10	90.93
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,280,000.00	1,756,955.00	3,523,045.00	33.28
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,244,200.00	1,013,450.00	230,750.00	81.45
2105	Нормативт зардал	2,170,500.00	2,140,000.00	30,500.00	98.59
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,170,500.00	2,140,000.00	30,500.00	98.59
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,539,200.00	73,021,700.00	5,517,500.00	92.97
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,459,500.00	6,720,000.00	4,739,500.00	58.64
210604	Урсгал засвар	67,079,700.00	66,301,700.00	778,000.00	98.84
2107	Томилолт, зочны зардал	7,251,600.00	6,772,000.00	479,600.00	93.39
210702	Дотоод албан томилолт	7,251,600.00	6,772,000.00	479,600.00	93.39
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,761,000.00	3,011,982.00	2,749,018.00	52.28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,073,100.00	0.00	1,073,100.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	540,000.00	10,000.00	98.18
210803	Даатгалын үйлчилгээ	444,500.00	118,200.00	326,300.00	26.59
210804	Тээврийн хэрэгслийн татвар	656,500.00	192,242.00	464,258.00	29.28
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	241,000.00	195,500.00	45,500.00	81.12
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,626,300.00	1,103,900.00	522,400.00	67.88
210807	Газрын төлбөр	1,169,600.00	862,140.00	307,460.00	73.71
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,152,000.00	53,308,940.00	14,843,060.00	78.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,847,500.00	42,032,940.00	14,814,560.00	73.94
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,304,500.00	11,276,000.00	28,500.00	99.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,136,900.00	27,558,700.00	578,200.00	97.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,136,900.00	27,558,700.00	578,200.00	97.95
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,737,300.00	16,737,300.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,399,600.00	10,821,400.00	578,200.00	94.93
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	632,900,000.00	411,864,069.00	221,035,931.00	65.08
223001	Бусад хөрөнгө	632,900,000.00	411,864,069.00	221,035,931.00	65.08
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	235,300,000.00	112,000,000.00	123,300,000.00	47.60
230001	Эргэж төлөгдөх зээл	235,300,000.00	112,000,000.00	123,300,000.00	47.60
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,856,038,300.00	1,456,412,049.32	399,626,250.68	78.47
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	261,023,800.00	261,023,800.00	0.00	100.00
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	261,023,800.00	261,023,800.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,262,838,300.00	1,163,921,078.32	98,917,221.68	92.17
320001	Орон нутгийн төсвөөс	1,262,838,300.00	1,163,921,078.32	98,917,221.68	92.17

35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	332,176,200.00	31,467,171.00	300,709,029.00	9.47
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	69,800,000.00	31,467,171.00	38,332,829.00	45.08
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	262,376,200.00	0.00	262,376,200.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	287,272,064.61	-	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	276,187,360.38	-	0.00

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,870,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,870,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,870,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,180,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,756,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,424,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,340,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,340,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,350,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,350,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,870,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,870,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,870,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.

- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 390.9 сая төгрөг болж, өмнөх оноос 274.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	545.2	390.9	-154.3
Дүн	545.2	390.9	-154.3

Эх сурвалж: Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 390.9 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий

орлогын 114.7 сая, ОНХС-ийн 191.1 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн 85.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 272.0 сая, эцсийн үлдэгдэл 195.4 сая төгрөг болж, 76.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төлбөртэй үйлчилгээний авлага	119.9	0.0	-119.9
Байгууллагаас авах авлага	27.0	0.06	-26.9
Хувь хүмүүсээс авах авлага	40.5	15.6	-24.9
Хувь хүмүүст олгосон зээлийн авлага	84.6	179.7	95.1
Дүн	272.0	195.4	76.6

/сая төгрөг/

Эх сурвалж: Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэл 195.4 сая төгрөг болж 76.6 сая төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төв 119.9, Ерөнхий боловсролын сургууль 25.6 сая, Цэцэрлэг 27.0 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн 18.0 сая төгрөгийн авлага буурснаас шалтгаалжээ.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 225.3 сая, эцсийн үлдэгдэл 60.7 сая төгрөг болж, 164.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	23.1		-23.1
Эм боох материал	23.7		-23.7
Бичиг хэргийн материал	22.5	2.0	-20.5
Аж ахуйн материал	101.8	8.8	-92.9
Сэлбэг хэрэгсэл	1.8		-1.8
Түлш, шатах тослох материал	0.8		-0.8
Барилгын засварын материал	3.5	0.1	-3.4
Хүнсний материал	21.3		-21.3
Бусад хангамжийн материал	26.7	45.7	19.0
Мал амьтад	0.00	4.0	4.0
Дүн	225.3	60.7	-164.6

/сая төгрөг/

Эх сурвалж: Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 60.7 сая төгрөг болж 164.6 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын бараа материалыг улсын төсвийн дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,787.9 сая, эцсийн үлдэгдэл 1.594.6 сая төгрөг болж, 4,193.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

0	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	5,602.9	1,475.1	-4,127.8
Барилга, байгууламж, орон сууц	5,441.0	1,380.2	-4,060.8
Хуримтлагдсан элэгдэл	-884.2	-527.5	356.7
Авто-тээврийн хэрэгсэл	411.0	327.5	-83.6

/сая төгрөг/

Хуримтлагдсан элэгдэл	-142.9	-115.5	27.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,114.1	625.6	-488.5
Хуримтлагдсан элэгдэл	-674.6	-376.5	298.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	294.6	61.2	-233.4
Хуримтлагдсан элэгдэл	-175.2	-43.1	132.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	40.7	0.0	-40.7
Бусад үндсэн хөрөнгө	261.8	277.0	15.2
Хуримтлагдсан элэгдэл	-166.1	-133.9	-17.8
Ном	32.5	0.0	-32.5
Биет бус хөрөнгө	184.9	119.5	-65.4
Програм хангамж	7.2	3.8	-3.3
Хуримтлагдсан элэгдэл	-6.2	-3.3	2.8
Бусад биет бус хөрөнгө	183.9	119.0	-64.8
Дүн	5,787.9	1,594.6	4,193.3

Эх сурвалж: Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,594.6 сая төгрөг болж 4,193.3 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын үндсэн хөрөнгийг улсын төсвийн дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 33.9 сая, эцсийн үлдэгдэл 5.3 сая төгрөг болж, 28.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр	33.9	5.3	-28.6
Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	0.2	-0.2
Байгууллагад төлөх өглөг	33.9	5.1	-28.8
Дүн	33.9	5.3	-28.6

Эх сурвалж: Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 5.3 сая төгрөг болж 28.6 төгрөгөөр буурсан нь байгууллагад төлөх өглөг буурснаас шалтгаалжээ.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,796.6 сая, эцсийн үлдэгдэл 2,236.4 сая төгрөг болж, 4,560.2 сая төгрөгөөр буурсан байна

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,622.6	773.7	-2,848.9
Хуримтлагдсан үр дүн	1,844.3	1,150.8	-693.4
Өмнөх үеийн үр дүн	615.9	5,491.7	4,875.4
Тайлант үеийн үр дүн	1,228.3	-4,340.8	-5,569.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,329.6	311.7	-1,017.9
Дүн	6,796.6	2,236.4	-4,560.2

Эх сурвалж: Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,236.4 сая төгрөг болж 4,560.2 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 1,844.3 сая төгрөг болж 1,150.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 386.5 сая, татварын бус орлого 13.9 сая, тусламж санхүүжилтийн орлого 891.1 сая, нийт 1,291.5 сая төгрөгийн орлого орсон байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 21.4 сая төгрөгийн 3 зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Өндөрхангай сумын Засаг даргын тамгын газар:

1. Засаг даргын тамгын газар нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 3.2 сая төгрөгийг ажилчдын аялал зугаалгад зориулж төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

2. Өндөрхангай сумын Засаг дарга нь Засаг даргын тамгын газрын жолоочтойгоо Хантер маркын авто машинд засвар хийлгэх зорилгоор гэрээ байгуулж, жолоочийн данс руу 18.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Хантер маркын машины эвдрэл гэмтлийг тогтоосон авто засварын газрын оношилгооны дүгнэлт байхгүй, засвар үйлчилгээ хийсэн эсэх нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байгаа зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Өндөрхангай сумын Соёлын төв:

1. Өндөрхангай сумын Соёлын төвийн даргад 0.2 сая төгрөгийн ээлжийн амралтын цалин илүү тооцон олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 986.5 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 145.3 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 622.8 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.5 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Өндөрхангай сумын 2022 оны төсвийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 6/04 дүгээр тогтоолоор 1,940.0 сая төгрөгөөр баталж 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 7/10 дугаар тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 84.0 сая төгрөгөөр бууруулж 1,856.0 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,856.0 сая төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 1,262.8 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 69.2 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 261.0 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 262.4 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,163.9 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 261.0 сая, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 31.5 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,466.3 сая төгрөгийг зарцуулж, 52.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,466.3 сая төгрөг буюу 90.2 хувьтай байгаа нь зардлыг 52.9 сая төгрөгөөр хэмнэж, 276.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарснаас шалтгаалжээ.

Өндөрхангай сумын ИТХ-ын 2022 оны тодотгосон төсөв батлах тухай 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 9/02 дугаар тогтоолд зааснаар Өндөрхангай сумын Засаг дарга тайлант онд 393.5 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 386.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 98.2 хувиар биелүүлсэн байна. Орлогын төлөвлөгөө тасрахад малд ногдох татвар, хадгаламжийн хүүгийн орлого, газрын төлбөрийн орлого дутуу бүрдсэнээс шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 9.8 сая орлогыг бүрдүүлж 9.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Нанжидмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/29 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 12.1 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,436.6 сая төгрөгийн 0.5 хувь буюу 12.1 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 9.7 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Өндөрхангай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/697 дугаар захирамжийн дагуу сумын орон нутгийн орлогоос 15.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн орлогод татаж авснаас шалтгаалан сумын орон нутгийн орлого 6.9 сая төгрөгөөр тасарч орон нутгийн орлогын төлөвлөгөө 98.2 хувийн биелэлттэй гарсан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 154 мэдээллээс хугацаандаа оруулсан 152 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг байршуулаагүй байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТЦУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/А.НАНЖИДМАА/

2023 оны 03 сарын 23-ны өдөр

